



Хөдөлмөр,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СЭРГЭЛТ, ҮНДЭГЭЭ, СУДАГААНЫ
ИНСТИТУТ



ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2023 ОНЫ II УЛИРАЛ

Улаанбаатар хот

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	8
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд.....	8
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд.....	19
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд.....	25
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	28
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	28
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах.....	32
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд.....	33
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА - 2022.....	38
МОНГОЛ УЛС ДАХ УР ЧАДВАРЫН ЭРЭЛТ – 2022 ОНЫ БАРОМЕТРИЙН СУДАЛГААНЫ УР ЧАДВАРЫН МОДУЛИЙН ГОЛ ҮР ДҮН.....	46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн ...9
Хүснэгт 2.	Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн 15
Хүснэгт 3.	Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар 19
Хүснэгт 4.	Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар 21
Хүснэгт 5.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр 24
Хүснэгт 6.	Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг 25
Хүснэгт 7.	Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг 27
Хүснэгт 8.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар 28
Хүснэгт 9.	Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар 30
Хүснэгт 10.	Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд 31
Хүснэгт 11.	Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр 40
Хүснэгт 12.	Эрэлттэй ажил мэргэжил, /хувь/ 42
Хүснэгт 13.	Ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 44
Хүснэгт 14.	Хомсдолтой ажил мэргэжил, дүнд эзлэх хувь 45



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2023 оны II улирал8
Зураг 2.	Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн 10

Зураг 3.	Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн	11
Зураг 4.	Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	12
Зураг 5.	Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	13
Зураг 6.	Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр.....	13
Зураг 7.	Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	14
Зураг 8.	Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар	16
Зураг 9.	Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар	16
Зураг 10.	Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин.....	17
Зураг 11.	Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар	20
Зураг 12.	Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, мянган хүнээр, улирлаар	20
Зураг 13.	Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар	22
Зураг 14.	Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр	23
Зураг 15.	ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар	23
Зураг 16.	Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар	24
Зураг 17.	Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар.....	26
Зураг 18.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар.....	29
Зураг 19.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар.....	29



Зураг 20.	Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, улсаар, дүнд эзлэх хувиар.....	32
Зураг 21.	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд.....	33
Зураг 22.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2023 оны VI сарын байдлаар.....	34
Зураг 23.	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны VI сарын байдлаар.....	35
Зураг 24.	Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны VI сарын байдлаар.....	36
Зураг 25.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны VI сарын байдлаар.....	37
Зураг 26.	Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны VI сарын байдлаар.....	37
Зураг 27.	2023 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, /хувь/.....	39
Зураг 28.	2023 оны ажиллах хүчний эрэлт, бүсээр, /хувь/.....	39
Зураг 29.	Ур чадварын зөрүү хамгийн их тулгардаг зургаан ажил үйлчилгээ.....	47
Зураг 30.	Хамгийн эрэлттэй зургаан ур чадвар.....	48
Зураг 31.	Хамгийн тэргүүнд сайжруулах шаардлагатай зургаан гол ур чадвар.....	49
Зураг 32.	Ур чадварын зөрүүг багасгахад шаардлагатай нөхцөлүүд.....	53

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2023 ОНЫ II УЛИРАЛ

2023 оны II улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 231.2** мянга (57.8 хувь) нь ажиллах хүч, **896.1** мянга (42.2 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

АЖИЛЛАХ ХҮЧ



1 231.2 МЯНГА



АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ



896.1 МЯНГА



АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2022 II 53.5% 46.5% **1 164.8**

2023 II 52.9% 47.1% **1 160.3**

↓ 0.4%
Өмнөх оны мөн үеэс

ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДТАЙ 3 САЛБАР



289.7 мянга (25.0%)

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй,
загас барилт, ан агнуур

56.0%
162.1 мянга



44.0%
127.6 мянга



150.1 мянга (12.9%)

Бөөний болон жижиглэн худалдаа,
машин, мотоциклийн завсар, үйлчилгээ

43.0%
64.5 мянга



57.0%
85.6 мянга



124.0 мянга (10.7%)

Боловсрол

22.9%
28.4 мянга



77.1%
95.6 мянга

АЖИЛГҮЙ ИРГЭД

2022 II 54.5% 45.5% **68.1** мянга

2023 II 61.6% 38.4% **70.9** мянга

↑ 4.1%
Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2023 оны II улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2127.2 мянга, үүнээс 1231.2 мянга (57.9 хувь) нь ажиллах хүч, 896.1 мянга (42.1 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 1.5 мянга буюу 0.1 хувиар буурсан бол өмнөх улирлаас 20.7 мянга буюу 1.0 хувиар өссөн байна.

Нийт ажиллах хүчний 53.4 хувь нь эрэгтэйчүүд, 46.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 37.8 хувь нь эрэгтэйчүүд, 62.2 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2023 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 32.2 мянгаар буурсан бол өмнөх улирлаас 41.1 мянгаар өссөн байна.

Ажиллах хүчний 1160.3 мянга (94.2 хувь) нь ажиллагчид, 70.9 мянга (5.8 хувь) нь ажилгүйчүүд байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 4.6 мянгаар (0.4 хувь) буурсан бол, өмнөх улирлаас 49.0 мянгаар (4.4 хувь) өссөн байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 27.7 мянгаар (28.1 хувь), өмнөх улирлаас 7.9 мянгаар (10.0 хувь) буурсан дүнтэй байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 30.7 мянга буюу 3.5 хувиар, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 49.9 мянга буюу 6.1 хувиар өссөн бол мөн хугацаанд боломжит ажиллах хүч 19.2 мянга буюу 43.1 хувиар буурсан байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам 2023 оны II улирлын байдлаар улсын хэмжээнд 102.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар, өмнөх улирлаас 10.8 хувиар буурсан. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 70.9 мянга (69.0 хувь) нь ажилгүй хүн, 6.4 мянга (6.3 хувь) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, 25.3 мянга (24.7 хувь) нь боломжит ажиллах хүч байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өмнөх улирлаар 25.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2022			2023		Өөрчлөлт	
	II	III	IV	I	II	он	улирал
Ажиллах хүч	1,263.4	1,259.6	1,222.9	1,190.1	1,231.2	-32.2	41.1
Үүнээс: эмэгтэй	581.6	596.1	567.4	569.0	573.7	-7.9	4.7
Ажиллагчид	1,164.9	1,191.5	1,158.2	1,111.3	1,160.3	-4.6	49.0
Үүнээс: эмэгтэй	541.1	565.1	540.8	538.2	546.5	5.4	8.3
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	14.0	9.9	5.1	6.5	0.2	1.3
Үүнээс: эмэгтэй	3.6	6.3	4.9	2.5	4.5	0.9	2.0
Ажилгүй хүн	98.5	68.1	64.6	78.8	70.9	-27.7	-7.9
Үүнээс: эмэгтэй	40.5	31.0	26.6	30.8	27.2	-13.3	-3.6
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	865.4	866.9	888.1	916.5	896.1	30.7	-20.4
Үүнээс: эмэгтэй	539.4	530.9	539.8	563.9	557.8	18.3	-6.1
Боломжит ажиллах хүч	44.6	41.4	43.4	31.2	25.4	-19.2	-5.8
Үүнээс: эмэгтэй	18.7	20.1	19.6	15.9	13.9	-4.9	-2.0
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	820.8	825.6	844.8	885.3	870.7	49.9	-14.6
Үүнээс: эмэгтэй	520.7	510.8	520.2	548.0	543.9	23.2	-4.1
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	149.4	123.5	117.9	115.1	102.7	-46.7	-12.4
Үүнээс: эмэгтэй	62.8	57.4	51.0	49.2	45.6	-17.2	-3.6


Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЭЗЭЛИЙН ТОЙМ

Ажиллагчдын тоо 2023 оны II улиралд ажиллагчдын тоо 1160.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 4.6 мянгаар буурсан бол өмнөх улирлаас 49.0 мянгаар өссөн байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2023 оны II улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 100 хүн тутмын 48 нь (48.6 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсролын салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэг (25 хувь)-ийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их өссөн салбарууд: боловсрол 21.1 мянгаар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 8.9 мянгаар, усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 3.2 мянгаар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 3.2 мянгаар, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 2.6 мянгаар, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 1.9 мянгаар, уул уурхай олборлолт 1.7 мянгаар тус бүр нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их буурсан салбарууд: боловсруулах үйлдвэрлэл 14.6 мянгаар, барилга 5.7 мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадам 5.3 мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын

нийгмийн хамгаалал 5.1 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 5.0 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 4.8 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 2.7 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 2.4 мянгаар тус бүр буурсан байна.


Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарын эрэгтэй ажиллагчдын тоо 2.2 мянгаар буурсан бол эмэгтэй ажиллагчдын тоо 5.4 мянгаар нэмэгдсэн байна. Үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо 2.0 мянгаар, эмэгтэй ажиллагчдын тоо 12.5 мянгаар тус бүр буурсан байна. Харин үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын тоо 12.5 мянгаар өссөн бол эрэгтэй ажиллагчдын тоо 5.7 мянгаар буурчээ.


Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 507.6 мянга (43.7 хувь) нь Улаанбаатар хотод, 652.7 мянга (56.3 хувь) нь хөдөө, орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 234.0 мянга (20.2% хувь) нь Хангайн бүсэд, 162.3 мянга (14.0% хувь) нь Баруун бүсэд, 156.4 мянга (13.5% хувь) нь Төвийн бүсэд, 99.9 мянга (8.6% хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 21.9 мянгаар (4.2 хувь), Төвийн бүс 19.4 мянгаар (11.0 хувь) буурсан бол Баруун бүс 17.6 мянгаар (12.2 хувь), Зүүн бүс 12.0 мянгаар (13.7 хувь), Хангайн бүс 7.1 мянгаар (3.1 хувь) нэмэгдсэн байна.

Зураг 6. Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо


2023 оны II улирлын байдлаар ажилгүй иргэдийн 43.7 мянга (61.6 хувь) нь эрэгтэй, 27.7 мянга (38.4 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 27.7 мянга буюу 28.0 хувиар буурчээ. Үүнд ажилгүй эрэгтэйчүүд 14.4 мянга буюу 24.8 хувиар, эмэгтэйчүүд 13.3 мянга буюу 32.8 хувиар буурсан байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 41.0 хувь нь, Баруун бүсэд 18.2 хувь нь, Хангайн бүсэд 19.2 хувь нь, Төвийн бүсэд 16.2 хувь нь, Зүүн бүсэд 5.6 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хангайн бүс 13.7 мянгаар, Баруун бүс 9.9 мянгаар, Зүүн бүс 2.1 мянгаар, Төвийн бүс 2.0 мянгаар буурсан бол Улаанбаатарт 0.1 мянгаар ажилгүй иргэд нэмэгджээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 15.8 мянга (22.3 хувь) нь 15-24 насны, 18.8 мянга (26.5 хувь) нь 25-34 насны, 20.0 мянга (28.3 хувь) нь 35-44 насны, 12.1 мянга (17.1 хувь) нь 45-54 насны, 4.2 мянга (5.9 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо буурахад 25-34 насны залуучууд голлон нөлөөлсөн ба өмнөх оны мөн үеэс 13.4 мянга буюу 41.7 хувиар буурчээ. Харин 15-24 насны ажилгүй иргэд 2.7 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт	2022				2023		Өөрчлөлт		
	I	II	III	IV	I	II	Он	Улирал	
Бүгд	104.4	98.5	68.1	70.9	98.5	70.9	-27.6	-27.7	
Хүйсээр	Эрэгтэй	66.8	58.1	37.1	43.7	58.1	43.7	-14.4	-14.4
	Эмэгтэй	37.6	40.5	31.0	27.2	40.5	27.2	-13.3	-13.3
	15-24	18.6	13.1	15.1	10.0	12.4	15.8	2.7	3.4
	25-34	32.4	32.2	18.4	19.6	20.3	18.8	-13.4	-1.5
Насны бүлгээр	35-44	31.9	26.0	18.0	18.9	23.1	20.0	-6.0	-3.0
	45-54	17.1	22.0	12.5	13.4	18.4	12.1	-9.9	-6.3
	55+	4.4	5.3	4.1	2.6	4.6	4.2	-1.1	-0.4
	Баруун бүс	20.4	22.8	14.9	14.8	10.3	12.9	-9.9	2.6
	Хангайн бүс	21.4	27.2	16.3	13.9	18.5	13.5	-13.7	-5.1
Бүсээр	Төвийн бүс	13.7	13.5	9.1	6.5	10.1	11.5	-2.0	1.3
	Зүүн бүс	3.8	6.1	3.9	4.1	4.4	3.9	-2.2	-0.4
	Улаанбаатар	45.2	29.0	24.0	25.3	35.5	29.1	0.1	-6.4

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 2.6 хувь нь магистр болон түүнээс дээш, 20.3 хувь нь бакалаврын дээд, 2.1 хувь нь дипломын дээд, 4.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 32.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 21.3 хувь нь бүрэн дунд, 12.1 хувь нь суурь, 2.3 хувь нь бага, 3.1 хувь нь боловсролгүй иргэд байна.

Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар

3 хүн
тутмын **1**


нь **Техникийн болон
мэргэжлийн**
боловсролтой байна.



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 5.8 хувь болж, өмнөх улирлаас 0.8 пунктээр, өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр буурсан. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 5.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.5 пунктээр мөн эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.2 мөн пунктээр буурсан байна. Насны бүлгээр харвал 20-24 насны залуучууд 13.0 хувь буюу өмнөх улирлаас 1.2 хувиар өссөн бол бусад насны бүлгүүд дунджаар 2.7 хувиар буурсан байна.

Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амдажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий ажиллах хүчний оролцооны түвшинг улирлаар авч үзэхэд 2023 оны II улиралд 57.9 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 пунктээр буурч Ковид цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшин (60.5%)-ээс бага байсаар байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны II улирлын байдлаар 54.5 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр буурсан байна.

Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2023 ОНЫ II УЛИРАЛ


ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ



⦿ ААНБ-ын төрлөөр



ТЭТГЭВЭР АВАГЧИД



ШИМТГЭЛИЙН ОРЛОГО



ДААТГУУЛАГЧ



☑ Даатгуулагчид, төрлөөр



САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ



ЗАРЛАГА



Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ



www.institute.gov.mn



(976)-77121286



httpsinfo@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд

2023 оны II улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 54.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.6 мянга буюу 5.1 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 91.4 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 8.6 хувь нь төсөвт байгууллагууд байна. Хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 2.6 мянга буюу 5.6 хувиар, төсөвт байгууллагын тоо 4684 буюу өөрчлөлтгүй байна.

Мөн 2023 оны II улирлын байдлаар нийгмийн даатгалд 1061.1 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 129.8 мянга (12.2 хувь) нь сайн дурын, 931.2 мянга (87.8 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 31.2 мянга буюу 3.0 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ			Даатгуулагч		
	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Нийт	Сайн дур	Албан журам
2020 I	42,862	38,286	4,576	831,943	108,042	723,901
II	46,762	42,185	4,577	961,692	156,624	805,068
III	47,818	43,225	4,593	1,051,309	172,892	878,417
IV	49,067	44,442	4,625	1,156,793	192,090	964,703
2021 I	46,242	41,668	4,574	845,802	100,956	744,846
II	48,738	44,137	4,601	962,387	136,141	826,246
III	50,625	46,001	4,624	1,062,030	147,827	914,203
IV	52,388	47,732	4,656	1,181,282	161,111	1,020,171
2022 I	48,462	43,807	4,655	891,825	107,417	784,354
II	51,776	47,096	4,680	1,029,922	133,167	896,755
III	53,425	48,733	4,692	1,141,946	146,833	995,113
IV	55,121	50,399	4,722	1,274,588	162,414	1,112,174
2023 I	51,282	46,616	4,666	925,215	108,644	816,571
II	54,405	49,721	4,684	1,061,097	129,881	931,216

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 34.4 мянга буюу 3.8 хувиар өссөн бол, сайн дурын дурын даатгуулагч 3.2 мянга буюу

ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЭЭЭЛИЙН ТОЙМ

2.5 хувиар буурсан дүнтэй байна.

Албан журмын даатгуулагчдын 667.1 мянга (71.6 хувь) нь хувийн аж ахуй нэгж байгууллагын, 264.1 мянга (28.4 хувь) нь төсөвт байгууллагын ажиллагчид байна. Өмнөх оны мөн үеэс хувийн аж ахуй нэгж байгууллагын даатгуулагч 33.9 мянгаар (5.4 хувь), төсөвт байгууллагын даатгуулагч 0.5 мянгаар (0.2 хувь) нэмэгдсэн.


Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдын 14.9 мянга (11.5 хувь) нь малчид, 3.6 мянга (2.8 хувь) нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, үлдсэн 111.2 мянга (85.7 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 2.0 мянга буюу 12.0 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1.8 мянга буюу 33.6 хувиар буурчээ.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, мянган хүнээр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд 2023 оны II улирлын байдлаар 484.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 17.5 мянга буюу 3.8 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 78.5 хувь нь өндөр насны тэтгэвэр, 13.0 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, 4.1 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.4 хувь цэргийн тэтгэвэр авсан байна.


Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2023 оны II улирлын байдлаар 380.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 16.6 мянга буюу 4.6 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 19.8 мянга болж 225 буюу 1.1 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 21.1 мянга болж 1.0 мянга буюу 5.1 хувиар нэмэгдсэн бол тахир дутуугийн тэтгэвэр авсан иргэд 63.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 318 буюу 0.6 хувиар буурчээ.

Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2020 I	427,247	320,602	67,912	19,853	18,880
II	434,186	327,799	67,663	19,711	19,013
III	439,481	333,026	67,769	19,584	19,102
IV	444,788	338,982	67,018	19,553	19,235
2021 I	449,419	344,287	66,344	19,511	19,277
II	451,845	347,235	65,771	19,377	19,462
III	454,298	350,091	65,197	19,437	19,573
IV	456,365	353,775	63,318	19,563	19,709
2022 I	462,607	359,783	63,439	19,588	19,797
II	467,420	364,173	63,491	19,625	20,131
III	471,387	368,050	63,280	19,705	20,424
IV	476,446	373,209	62,702	19,743	20,792
2023 I	480,312	376,643	63,097	19,744	20,828
II	484,981	380,843	63,133	19,850	21,155

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэд 2023 оны II улирлын байдлаар 110.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 11.8 мянга буюу 9.7 хувиар буурсан байна. Тэтгэмж авсан иргэд 65.9 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 27.7 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 6.3 хувь нь оршуулгын тэтгэмж авсан байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2023 оны II улирлын байдлаар 72.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар, оршуулгын тэтгэмж авсан иргэд 6.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 30.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өссөн байна.

Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж



Жирэмсний болон амаржсаны тэтгэмж




Оршуулгын тэтгэмж



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 2023 оны II улирлын байдлаар 5.3 мянга болж, өмнөх оны мөн үетэй ижил байна. ҮОМШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 66.7 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, 11.1 хувь нь ҮОМШӨ-ний сувилал, 13.4 хувь нь тэтгэмж, төлбөр, 8.8 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэрт хамрагдсан байна.

Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2023 оны II улирлын байдлаар 1587.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 362.6 тэрбум төгрөг буюу 29.6 хувиар, нийгмийн даатгалын зарлага 1772.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 182.6 тэрбум төгрөг буюу 11.5 хувиар нэмэгдсэн.

2023 оны II улирлын байдлаар шимтгэлийн орлогын 83.0 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.5 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 6.8 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 1.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 90.5 хувийг тэтгэврийн даатгалын сан, 5.6 хувийг тэтгэмжийн даатгал сан, 0.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр


Үзүүлэлт	2022 II		2023 II		Өөрчлөлт	
		Эзлэх %		Эзлэх %	Тоо	Хувь
НД-ын шимтгэлийн орлого	1225.1	100.0%	1587.7	100.0%	362.6	29.6%
Тэтгэвэр	1025.9	83.7%	1318.3	83.0%	292.3	28.5%
Тэтгэмж	98.9	8.1%	135.0	8.5%	36.0	36.4%
ҮОМШӨ	81.4	6.7%	108.4	6.8%	26.9	33.1%
Ажилгүйдэл	18.6	1.5%	26.0	1.6%	7.3	39.3%
НД-ын зарлага	1590.3	100.0%	1772.9	100.0%	182.6	11.5%
Тэтгэвэр	1466.4	92.2%	1604.2	90.5%	137.8	9.4%
Тэтгэмж	74.2	4.7%	99.9	5.6%	25.7	34.7%
ҮОМШӨ	16.2	1.0%	16.8	0.9%	0.6	3.5%
Ажилгүйдэл	33.5	2.1%	51.9	2.9%	18.5	55.2%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2023 оны II улирлын байдлаар 15.8 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 51.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 1.4 мянга буюу 9.9 хувиар, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 18.5 тэрбум төгрөг буюу 55.2 хувиар нэмэгджээ.

2022 оны II улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 2.3 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2023 оны II улиралд 3.3 сая болж, 41.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд

Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2023 оны II улирлын байдлаар 1.890.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 345.6 мянга буюу 22.4 хувиар, өмнөх улирлаас 59.2 мянга буюу 3.2 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалингийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 2096.4 мянган төгрөг, эмэгтэйчүүд 1675.6 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2023 оны II улиралд 420.8 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 140.3 мянгаар өссөн байна.

Өөрөөр хэлбэл 2023 оны II улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 79.9 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр өссөн нь хүйсээрх цалингийн ялгаа өссөөр байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг


Үзүүлэлт	2021		2022				2023		Өөрчлөлт	
	I	II	I	II	III	IV	I	II	Он	Улирал
Дундаж цалин	1450.1	1544.4	1573.1	1750.2	1830.8	1890.0	345.6	59.2	1450.1	1544.4
Эрэгтэй	1577.3	1681.3	1746.9	1934.3	2044.2	2096.4	415.1	52.2	1577.3	1681.3
Эмэгтэй	1317.7	1400.8	1396.3	1559.7	1610.9	1675.6	274.8	64.7	1317.7	1400.8

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг нь ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2023 оны II улирлын байдлаар медиан цалин 1435.2 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 275.0 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар, өмнөх улирлаас 82.3 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн байна.

2023 оны II улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 550.0 мянгаас 1.5 сая төгрөгийн цалинтай 41.8 хувь, харин 550.0 мянга хүртэл төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь буюу 11.7 хувь байна.

Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2023 оны II улирлын байдлаар 1-9 ажиллагчидтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 863.0 мянгаар, 10-49 ажиллагчидтай байгууллагынх 384.8 мянгаар, 50-99 ажиллагчидтай байгууллагынх 130.6 мянгаар бага байгаа бол, 100-199 ажиллагчидтай байгууллагынх 60.5 мянгаар, 200, түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 759.2 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 200 дээш ажиллагчидтай байгууллагын ажиллагчдын дундаж цалин хамгийн их буюу 553.4 мянган төгрөг (26.4 хувиар)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг

Ажиллагчдын тооны бүлэг	2022 I			2023 I			Өөрчлөлт	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	1,544.4	1,681.3	1,400.8	1,890.0	2,096.4	1,675.6	345.6	22.4%
1-9	945.3	949.7	940.9	1,027.0	1,129.6	1,130.5	81.7	8.6%
10-49	1,259.8	1,263.1	1,256.9	1,505.2	1,539.3	1,475.4	245.4	19.5%
50-99	1,452.3	1,548.8	1,364.5	1,759.4	1,857.2	1,669.4	307.1	21.1%
100-199	1,634.5	1,746.4	1,521.4	1,950.5	2,091.3	1,807.1	316.0	19.3%
200 дээш	2,095.8	2,324.7	1,781.9	2,649.2	3,023.6	2,148.0	553.4	26.4%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.5 сая төгрөг, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт ажиллагчдын цалин хамгийн бага буюу 1.1 сая төгрөг байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2023 ОНЫ II УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



5737

51.5%
Эмэгтэй

2.9%
Хөгжлийн
бэрхшээлтэй

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



4323

52.4%
Эмэгтэй

3.0%
Хөгжлийн
бэрхшээлтэй

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА



16 950



48.4%
Эрэлт хангасан хувь

↑ 1.5%
Өмнөх оны
мөн үеэс

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН



8 199

50.9%
Эмэгтэй

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар


11 201
Гадаадын иргэд



9 983 (89.1%)
Эрэгтэй



1 227 (10.9%)
Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ



www.institute.gov.mn



(976)-77121286



https:info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэдийн тоо 2023 оны II улирлын эцэст 5.7 мянга (үүний 2.9 мянга буюу 51.5 хувь нь эмэгтэй) байна. Насны бүлгээр авч үзвэл, 0.8 мянга (14.8 хувь) нь 15-24 насны, 1.8 мянга (31.4 хувь) нь 25-34 насны, 1.5 мянга (27.2 хувь) нь 35-44 насны, 1.0 мянга (17.9 хувь) нь 45-54 насны, 0.5 мянга (8.7 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.


Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч /сарын эцэст/			Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/		
		Эмэгтэй	Эзлэх хувь		Эмэгтэй	Эзлэх хувь
2020 I	31,785	16,285	51.2%	19,394	10,009	51.6%
II	30,320	15,367	50.7%	19,563	10,001	51.1%
III	27,504	14,301	52.0%	17,829	9,446	53.0%
IV	29,952	15,390	51.4%	18,103	9,535	52.7%
2021 I	25,105	12,774	50.9%	16,775	8,650	51.6%
II	26,991	13,837	51.3%	17,650	9,202	52.1%
III	21,804	11,316	51.9%	15,053	7,895	52.4%
IV	27,950	14,510	51.9%	18,644	9,821	52.7%
2022 I	24,255	12,019	49.6%	16,622	8,345	50.2%
II	24,184	12,075	49.9%	16,282	8,210	50.4%
III	19,832	10,609	53.5%	13,545	7,389	54.8%
IV	21,256	11,069	52.1%	13,966	7,326	52.4%
2023 I	14,246	7,238	50.7%	9,069	4,651	51.1%
II	5,737	2,954	51.5	4,323	2,265	52.4%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 4.3 мянга байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2.0 мянга (47.6 хувь) нь эрэгтэйчүүд, 2.2 мянга (52.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл, 1.4 мянга (14.2 хувь) нь 15-24 насны, 1.4 мянга (32.8 хувь) нь 25-34 насны, 1.1 мянга (26.8 хувь) нь 35-44 насны, 0.7 мянга (17.4 хувь) нь 45-54 насны, 0.4 мянга (8.8 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар¹

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.6 хувь нь боловсролгүй, 4.4 хувь нь бага, 9.0 хувь нь суурь, 49.7 хувь нь бүрэн дунд, 5.9 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.1 дипломын болон бакалаврын дээд, 1.5 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.4 хувь нь боловсролгүй, 4.4 хувь нь бага, 9.5 хувь нь суурь, 47.5 хувь нь бүрэн дунд, 6.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 24.8 дипломын болон бакалаврын дээд, 1.6 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

¹ ХХҮЕГ-ын E-Job бүртгэлийн системийн шинэчлэлтэй холбоотойгоор 2023 оны статистик тоон мэдээллүүд бүрэн нийтэд тархаагдаагүй байна

2023 оны II улиралд 16.9 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 8.2 мянган иргэнийг ажилд зуучилж, нийт эрэлтийн 48.3 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 7.3 мянга буюу 30.3 хувиар, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 5.4 мянга буюу 66.7 хувиар буурсан байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 1.7 мянга (21.5 хувь) нь 15-24 насны, 2.5 мянга (31.0 хувь) нь 25-34 насны, 2.0 мянга (24.6 хувь) нь 35-44 насны, 1.3 мянга (16.1 хувь) нь 45-54 насны, 0.5 мянга (6.6 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2023 оны II улиралд хөдөлмөрийн эрэлт хангасан хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эрэлт		Эрэлт хангасан хувь
			Эмэгтэй	Эзлэх хувь	
2020 I	7,595	4,489	2,307	51.4%	59.1%
II	28,036	15,250	7,330	48.1%	54.4%
III	42,433	21,672	10,858	50.1%	51.1%
IV	58,022	33,006	16,651	50.4%	56.9%
2021 I	6,413	3,066	1,545	50.4%	47.8%
II	20,352	11,416	5,542	48.5%	56.1%
III	32,656	17,636	9,068	51.4%	54.0%
IV	51,034	29,929	15,460	51.7%	58.6%
2022 I	9,322	3,901	2,003	51.3%	41.8%
II	24,320	13,670	6,709	49.1%	56.2%
III	32,972	18,897	9,499	50.3%	57.3%
IV	55,211	32,290	16,412	50.8%	58.5%
2023 II	16,950	8,199	4,149	50.6%	48.3%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2023 оны II улиралд ирсэн ажлын байрны захиалгын 2.5 мянга нь уул уурхай олборлолт (14.6 хувь), 2.3 мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (13.5 хувь), 1.9 мянга нь боловсруулах үйлдвэрлэл (11.6 хувь), 1.8 мянга нь цахилгаан, хий, уур, агааржуулалт (11.0 хувь)-ын салбараас ирсэн байна.

2023 оны II улирлын байдлаар уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл

ажиллагаа, барилгын салбарын эрэлтийг 70.0-95.0 хувьтай хангасан бол боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, Урлаг, үзвэр, тоглоом наадам, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарын эрэлтийг 37.0 хувиас доогуур буюу хангалтгүй байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга		Ажилд зуучлагдсан иргэн		Эрэлт хангасан хувь
	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь	
Бүгд	16950	100.0%	8199	100.0%	48.4%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2290	13.5%	1250	15.2%	54.6%
Уул уурхай, олборлолт	1866	11.0%	844	10.3%	45.2%
Боловсруулах үйлдвэрлэл	2481	14.6%	934	11.4%	37.6%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	627	3.7%	43	0.5%	6.9%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	390	2.3%	280	3.4%	71.8%
Барилга	1973	11.6%	515	6.3%	26.1%
Бөөний болон жижиглэн худалдаа	1753	10.3%	872	10.6%	49.7%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	271	1.6%	79	1.0%	29.2%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	785	4.6%	459	5.6%	58.5%
Мэдээлэл, холбоо	125	0.7%	179	2.2%	143.2%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	188	1.1%	97	1.2%	51.6%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	43	0.3%	1	0.0%	2.3%
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	195	1.2%	150	1.8%	76.9%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	483	2.8%	281	3.4%	58.2%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	1331	7.9%	904	11.0%	67.9%
Боловсрол	1285	7.6%	812	9.9%	63.2%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	518	3.1%	243	3.0%	46.9%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	112	0.7%	60	0.7%	53.6%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	190	1.1%	159	1.9%	83.7%
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	36	0.2%	34	0.4%	94.4%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	8	0.0%	3	0.0%	37.5%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах

2023 оны II улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 88 улсын 11.2 мянган иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 5.0 мянга буюу 80.6 хувиар, өмнөх улирлаас 5.4 мянга буюу 95.2 хувиар өссөн байна. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 9.9 мянга (89.1 хувь) нь эрэгтэйчүүд, 1.1 мянга (10.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 39.4 хувь нь Улаанбаатар хотод, 41.6 хувь нь Төвийн бүсэд, 13.6 хувь нь Зүүн бүсэд, 3.2 хувь нь Хангайн бүсэд, 2.2 хувь нь Баруун бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл 7042 (62.8 хувь) нь Хятад, 671 (6.0 хувь) нь Энэтхэг, 431 (3.8 хувь) нь Орос, 400 (3.6 хувь) нь Турк, 390 (3.5 хувь) нь Вьетнам, 360 (3.2 хувь) нь БНСУ, 360 (3.2 хувь) нь Филиппин, 167 (1.5 хувь) нь Өмнөд Африк, бусад улсаас 599 (5.3 хувь) иргэн байна.

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, улсаар, дүнд эзлэх хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2023 оны II улирлын байдлаар 310 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 277 (89.4 хувь) нь Өмнөд Солонгос, 33 (10.6 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 231 (74.5 хувь) нь эрэгтэйчүүд, 79 (25.5 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 17.7 хувь 20-24 насны, 31.3 хувь нь 25-29 насны, 27.4 хувь нь 30-34 насны, 16.5 хувь нь 35-39 насны, үлдсэн 3.9 хувь нь 40, түүнээс дээш насныхан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 53.5 хувь нь бүрэн дунд, 5.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 40.0 хувь нь бакалаврын, 1.3 хувь нь магистр, докторын түвшний боловсролтой байна.

Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2023-2024 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 4 хөтөлбөр, 20 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт 18.6 мянган иргэнийг хамруулж, 23.2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг хөтөлбөрийн төрлөөр авч үзвэл 40.8 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 12.6 хувь нь Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, 8.0 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 38.6 хувь нь Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг төсөл, хөтөлбөрөөр авч үзвэл 2.1 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 64.9 хувь нь Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, 20.8 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 12.2 хувь нь Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд зарцуулагдсан байна.

Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2023 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7.6 мянган иргэн хамрагдаж, 496.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 37.9 хувь нь суурь ур чадварын сургалт зохион байгуулах, 27.5 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 27.5 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 6.3 хувь нь богино хугацааны ур чадвар олгох сургалт, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт, 0.8 хувь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд сургалтад хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 61.8 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт, 18.6 хувь нь суурь ур чадварын сургалт, 8.3 хувь нь богино хугацааны ур чадвар олгох сургалт, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт, 7.4 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 4.0 хувь нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.

Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 2022 оны эцэст 11.8 мянган иргэн хамрагдаж, 21345.7 сая төгрөг зарцуулж, 4377 ажлын байр бий болсон байна.

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 38.1 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 18.5 хувь нь иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох, 17.2 хувь нь малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, 10.8 хувь нь борлуулалтын дэмжлэг, үлдсэн 15.3 хувь нь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 70.2 хувь нь иргэн, аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ, 22.5 хувь нь малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, үлдсэн 7.3 хувь нь бусад арга хэмжээнд зарцуулсан.

Зураг 24. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны II улирлын байдлаар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2023 оны хагас жилийн байдлаар 1487 иргэн хамрагдаж, 4818.7 сая төгрөгийг зарцуулаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 94.9 хувь нь санхүүгийн дэмжлэг, 4.2 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулахад, 0.9 хувь нь борлуулалтын дэмжлэг, түрээсийн хөнгөлөлт, ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг, бусад үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны II улирлын байдлаар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7209 иргэн хамрагдаж, 2829.7 сая төгрөгийг зарцуулаад байна.

Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэдийн 51.8 хувь нь нийтийг хамарсан ажил, 44.2 хувь нь мод тарих үйлчилгээнд хамрагдсан бол зарцуулсан хөрөнгийн 48.5 хувь нь нийтийг хамарсан ажил, 45.0 хувь нь мод тарих үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 26. Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2023 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА - 2022

2023 оны ажиллах хүчний нийт эрэлт

Улсын хэмжээнд 2023 онд 84.6 мянган ажлын байр бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 6.0 мянга гаруй ажлын байр буюу 8.4 хувиар өсч, хөдөлмөрийн зах зээлийн олон жилийн ерөнхий чиг хандлага хадгалагдах төлөвтэй байна. Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт тодорхой хувиар өсөх боломжтой байдаг.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаарх ажиллах хүчний эрэлт

Энэ онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь өмнөх жилүүдийн адил бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбар бөгөөд 2023 онд хөдөлмөрийн зах зээлд гол эерэг нөлөөг үзүүлэх салбарууд болж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарт жилийн нийт эрэлтийн 26.0 хувь буюу 22.0 мянган ажиллах хүчний эрэлт, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.5 мянга буюу нийт эрэлтийн 11.2 хувь бий болох ч өмнөх жилийн судалгааны үр дүнгээс буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллах хүчний эрэлт 7.9 хувиар буурахаар байна. 7.0 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 7.0 хувиар буурах төлөвтэй байна. Харин барилгын салбарт 13.3 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь нийт эрэлтийн 15.7 хувийг эзэлж, өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 15.9 хувиар өсөх үзүүлэлттэй байна.

Ажиллах хүчний эрэлт өндөр байх бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт 2023 оны ажиллах хүчний эрэлтийн 52.9 хувийг бүрдүүлж байна.


Зураг 27. 2023 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, /хувь/



Байршлаарх ажиллах хүчний эрэлт

Энэ онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний эрэлтийг байршлаар тодруулбал, 73.5 хувь буюу 62.1 мянга нь Улаанбаатар хотод, 12.3 хувь буюу 10.4 мянга нь Төвийн бүсэд, 7.5 хувь буюу 6.4 мянга нь Хангайн бүсэд, 5.0 хувь буюу 4.2 мянга нь Баруун бүсэд, үлдсэн хувь нь Зүүн бүсэд бий болох төлөвтэй байна.

Зураг 28. 2023 оны ажиллах хүчний эрэлт, бүсээр, /хувь/



Дүнд эзлэх хувь

■ Байнгын ажлын байр ■ Түр ажлын байр

Ажлын байрны төрлөөр

Хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг харуулах нэг үзүүлэлт нь шинээр бий болох ажлын байр бөгөөд 2023 онд бий болох нийт ажиллах хүчний эрэлтийн 52.7 мянга буюу 62.4 хувь нь шинэ ажлын байранд ажилтан авах эрэлт байгаа нь хөдөлмөрийн зах зээлд боломжтойг харуулж байна. Нийт эрэлтийн 31.8 мянга буюу 31.8 хувь нь сул ажлын байр байгаа нь өмнөх оныхоос 8.2 мянгаар өссөн үзүүлэлт болжээ.

Хүснэгт 11. Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт /мян.хүн/		Дүнд эзлэх хувь	
	Шинэ	Сул	Шинэ	Сул
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.7	0.7	3.2	2.2
Уул уурхай, олборлолт	3.4	1.1	6.4	3.4
Боловсруулах үйлдвэрлэл	5.3	4.1	10.1	13.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.2	0.1	0.7
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.3	0.1	0.6	0.3
Барилга	10.3	3.0	19.6	9.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	13.3	8.8	25.2	27.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.5	0.5	2.9	1.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.6	1.2	5.0	3.9
Мэдээлэл, холбоо	1.6	0.4	3.0	1.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.5	0.2	2.9	0.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.4	0.8	1.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3.4	0.8	6.5	2.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.3	2.7	4.3	8.6
Боловсрол	2.0	2.8	3.7	8.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.0	1.7	1.8	5.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.4	0.4	0.7	1.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.8	2.7	3.4	8.4
Нийт	52.7	31.8	100	100

Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд бий болох шинэ ажлын байрны 25.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 19.6 хувь нь барилгын салбарт, 10.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус бий болох бол сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн 49.8 хувь нь мөн эдгээр салбаруудад бий болохоор харагдаж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд өмнөх жилүүдийн үр дүнгээр салбаруудад шинэ ажлын байрны эзлэх хувь өндөр байсан бөгөөд энэ жил энэ үзүүлэлт багасаж сул ажлын байрны эзлэх хувь өссөн үр дүнтэй байна.

Ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлт

Ажиллах хүчний эрэлтийн ажил мэргэжлийн бүлгээрх тооцооллыг энд тайлбарлая.

Энэ оны ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр авч үзвэл ажиллах хүчний нийт эрэлтийн 27.4 хувийг мэргэжилтэн буюу II бүлгийн ажил мэргэжил, 18.9 хувийг энгийн ажил мэргэжил буюу IX бүлгийн, 18.6 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан буюу VII бүлгийн ажил мэргэжлийн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн эрэлт эзэлж, нийт ажиллах хүчний эрэлтийн 64.9 хувийг бүрдүүлж байна. Энэ удаад мэргэжилтэн бүлгийн ажил мэргэжлүүдийн эрэлтийн эзлэх хувь өмнөх жилийн дүнгээс өссөн бөгөөд харин энгийн ажил мэргэжлийн бүлгийн нийт эрэлтэд эзлэх хувийн жин өмнөх оныхоос буурах үзүүлэлттэй байна.

Ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл өмнөх жилүүдийн адил тухайн жилд ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарт харьяалагдах ажил мэргэжлээрх эрэлт илүү өндөр байх чиг хандлага өөрчлөгдөөгүй байна. Мөн тусгайлсан мэргэжил, боловсрол, ур чадвар шаардахгүй энгийн ажил мэргэжлийн эрэлт өндөр хэвээр хэдий ч өмнөх оны дүнгээс буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, ажиллах хүчний нийт эрэлтийн 5.1 хувийг цэвэрлэгч, үйлчлэгч, 4.1 хувийг үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, 3.2 хувийг барилгын туслах ажилтан зэрэг ажил мэргэжлүүд эзэлж байна. Эдгээр ажил мэргэжлийн эрэлт жил бүрийн ажил мэргэжлээрх эрэлтэд багагүй хувийг эзэлдэг бөгөөд энэ оны нийт эрэлтийн 12.4 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн засалчин, шаварчин, хүнд даацын авто машины операторч, худалдагч, жолооч, туслах сувилагч, мужаан, тогооч, гагнуурчин, арматурчин, автомашины хөдөлгүүрийн

засварчин, моторчин зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байгаа бол дээд боловсролын хувьд нягтлан бодогч, англи хэлний багш, бөөний худалдааны менежер, дотоод шаталтат хөдөлгүүрийн инженер, малын эмч зэрэг ажил мэргэжлүүд эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдэж байна.

Хүснэгт 12. Эрэлттэй ажил мэргэжил, /хувь/

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	712311	Засалчин, шаварчин	5.2	11	142012	Менежер, бөөний худалдааны /дэлгүүрийн/	1.7
2	911211	Цэвэрлэгч/ үйлчлэгч, албан тасалгааны	5.1	12	711515	Мужаан, засварын	1.6
3	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	4.1	13	226201	Эм зүйч	1.6
4	833212	Операторч, хүнд даацын авто машины	3.2	14	343411	Тогооч	1.6
5	931211	Туслах ажилтан, барилгын туслах	3.2	15	214417	Инженер, дотоод шаталтат хөдөлгүүрийн	1.5
6	521111	Мухлаг /лангууны худалдагч	3.2	16	933316	Ачигч, дэлгүүрийн	1.5
7	322101	Туслах сувилагч	3.2	17	225011	Малын эмч	1.4
8	241112	Нягтлан бодогч	2.6	18	721214	Гагнуурчин	1.3
9	832211	Жолооч, машины	2.6	19	711411	Арматурчин	1.3
10	231038	Багш, англи хэлний	2.0	20	723119	Автомашин хөдөлгүүрийн засварчин, моторчин	1.3

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ

Өнгөрөгч онд аж ахуйн нэгж байгууллагын 15.9 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн гэсэн нь өмнөх оноос 3.2 пунктээр буурсан үзүүлэлт болжээ. Ажиллах хүчний хомсдолыг тархааж үзвэл жилийн хугацаанд 42.7 мянган ажиллах хүчний хомсдол үүссэн нь хомсдолд өртсөн ААНБ-ын эзлэх хувь буурсан ч хомсдолтой ажиллагчид 5.8 мянгаар өссөн үзүүлэлт болжээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 31.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 22.5 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Үүнээс гадна барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 18.7 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт хомсдолын 27.5 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд өнгөрсөн жил зөвхөн дээрх 3 салбаруудын хүрээнд ажиллах хүчний хомсдолоос үүдэлтэй 21.4 мянган ажлын байр байжээ. Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий агааржуулалтын салбар, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхай, олборлолтын салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн тохиолдолд эзлэх хувь хамгийн бага байна.

Хүснэгт 13. Ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний хомсдол	
	Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.3	3.0
Уул уурхай, олборлолт	0.4	1.0
Боловсруулах үйлдвэрлэл	6.1	14.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.3
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.1	0.3
Барилга	5.6	13.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	9.6	22.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.5	1.2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.0	4.6
Мэдээлэл, холбоо	0.7	1.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.4	0.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.8	1.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3.1	7.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.6	6.2
Боловсрол	2.7	6.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.0	2.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.5	1.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.0	11.7
Нийт	42.7	100.0

Ажил мэргэжлээрх ажиллах хүчний хомсдол

Ажил мэргэжил хувьд хамгийн их хомсдолтой байсан нь ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн буюу өмнө яригдсан ажилтан ажилд орсон ажлаас гарсан тохиолдлуудын хүрээн дэх ажил мэргэжлүүд түлхүү нэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл ажиллах хүчний хөдөлгөөн ихтэй байсан ажил мэргэжлүүд хомсдолтой ажил мэргэжлээр нэрлэгджээ. Мөн энэ нь эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалтад ч нөлөөлсөн

байдалтай байна. Өөрөөр хэлбэл тухайн онд хомсдолтой байсан ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт хангагдаагүйгээс ирэх оны ажиллах хүчний эрэлтэд ч өндөр хувьтай дурьдагдаж, хөдөлмөрийн зах зээлд гол нөлөөг үзүүлсээр байна. Доорх жагсаалтаас ажил мэргэжлийн үзүүлэлтүүдийг харна уу.

Хүснэгт 14. Хомсдолтой ажил мэргэжил, дүнд эзлэх хувь

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	911211	Цэвэрлэгч/ үйлчлэгч, албан тасалгааны	8.2	11	214417	Инженер, дотоод шаталтат хөдөлгүүрийн	2.0
2	931211	Туслах ажилтан, барилгын туслах	5.0	12	241112	Нягтлан бодогч	1.9
3	225011	Малын эмч	4.2	13	711515	Мужаан, засварын	1.8
4	962911	Хаалгач	3.7	14	933316	Ачигч, дэлгүүрийн	1.7
5	522313	Дэлгүүрийн туслах ажилтан	3.5	15	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	1.7
6	142012	Менежер, бөөний худалдааны / дэлгүүрийн/	3.1	16	215228	Инженер, цахим зүйн /техник хангамжийн/ (компьютерын)	1.7
7	812127	Операторч, автогрейдерийн	2.9	17	521111	Мухлаг /лангууны худалдагч	1.6
8	832211	Жолооч, машины	2.9	18	833212	Операторч, хүнд даацын авто машины	1.3
9	343411	Тогооч	2.4	19	712311	Засалчин, шаварчин	1.2
10	122111	Дарга, эрхлэгч / менежер/, алба, хэлтэс, тасгийн / борлуулалтын/	2.2	20	721214	Гагнуурчин	1.2

Дурьдагдсан ажил мэргэжлүүдийн ажиллах хүчний хомсдолд эзлэх хувийн жин 54.4 хувь байна.

МОНГОЛ УЛС ДАХ УР ЧАДВАРЫН ЭРЭЛТ – 2022 ОНЫ БАРОМЕТРИЙН СУДАЛГААНЫ УР ЧАДВАРЫН МОДУЛИЙН ГОЛ ҮР ДҮН

БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Ажил олгогчдын хайж буй үр чадвар²

2022 оны Барометрийн судалгааны Ур чадварын модулийн гол үр дүн

Ажиллах хүчний үр чадварын хомсдол Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болж байна уу? Ажилтны ямар үр чадварыг ажил олгогч чухалчилж байна вэ? Ямар үр чадвар Монгол ажилтнуудад дутагдаж байна вэ? Монголын боловсролын систем нь ажил олгогчдод шаардлагатай үр чадвар бүхий хүмүүсийг бэлтгэж байна уу? Монголын аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтнуудынхаа үр чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулж байна уу? Энэхүү бодлогын хураангуй нь 2022 оны Барометрийн судалгаанд тусгайлан боловсруулж хавсарга болгон хэрэгжүүлсэн Ур чадварын модуль судалгаагаар гарсан үр дүнг ашиглан эдгээр асуултад хариулт өгөхөд чиглэсэн.

Гол үр дүн


Ур чадвар шаардсан ажлын байранд шинэ ажилтан авах нь Монголын олон аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэлтэй байна. Энэ нь дараах хоёр үндсэн шалтгаантай: (а) ажилд орохыг хүсэгч цөөн, (б) ажил горилогчид нь байгууллага, аж ахуйн нэгжийн өгч чадах хэмжээнээс өндөр цалин хөлс шаарддаг. Мөн ажил горилогчид нь шаардагдаж буй үр чадвараар дутмаг байгаа талаар олон байгууллага, аж ахуйн нэгжүүд гомдолтой байна³. Эдгээр гурван шалтгаан бүгд нийлээд үр чадвартай ажиллах хүч хомсдолтой байгааг илтгэж байна. Энэхүү үр чадварын хомсдол нь Монголын аж ахуйн нэгж, байгууллагын өсөж хөгжих боломжийг хязгаарлаж байна.

2 Энэхүү бодлогын хураангуйг Дэлхийн банкны зөвлөх Ян Рутковский бэлтгэв.

3 Ажилтан сонгож авахад хүндрэлтэй байсан бусад, гэхдээ харьцангуй цөөн дурдагдсан бусад шалтгаанд ажил горилогчийн ажлын туршлага дутмаг байсан, эсвэл ажил горилогчийн зүгээс хөдөлмөрийн нөхцөлийг хангалтгүй гэж үзсэн зэргийг дурьдаж болно.

Шинэ ажилтнуудыг ажилд авах нь хэдийгээр хүндрэлтэй байдаг ч, ихэнх ажил олгогчид ур чадвараар дутмаг ажиллах хүч тэдний одоогийн үйл ажиллагаанд томоохон саад тотгор үзүүлж байгаа гэж үзэхгүй байна. Гэхдээ, “ажиллах хүчний ур чадвар хангалтгүйгээс тэдний үйл ажиллагаа болон өсөлтөд саад тотгор учруулж байна” хэмээн цөөнгүй байгууллага, аж ахуйн нэгжүүд үзэж байна. Эдгээр нь ихэнхдээ “орчин үеийн” (“уламжлалт”-аас ялгаатай) хэв шинжтэй буюу инновацлаг, өргөжин тэлж буй, экспортын баримжаатай, том аж ахуйн нэгж, байгууллагууд юм. Том арван аж ахуйн нэгж, байгууллага тутмын зургаа нь, жишээлбэл, “ажиллах хүчний ур чадвар хангалттай биш байгаа нь тэдний үйл ажиллагаанд дунд зэргийн саад бэрхшээл учруулдаг” гэж үзэж байна. Иймд орчин үеийн, инновацлаг компани, аж ахуйн нэгжүүдийн хувьд ур чадварын зөрүү үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байгаа асуудал Монгол Улсад үүсээд байна. Ажиллах хүчний ур чадвар хангалтгүй байгаа нь ялангуяа шинэ технологи нэвтрүүлэхэд хүндрэл учруулж, бизнесийн боломжийг алдагдуулж, ашиг орлого буурахад хүргэдэг. Ур чадварын зөрүү хамгийн их сөргөөр нөлөөлж байгаа үйл ажиллагааг (ажил олгогчдын 40-50 орчим хувийн мэдээлснээр) Зураг 1-д үзүүлэв. Эдгээр нь бүгд Монголын эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой, нэмүү өртөг бүтээх ажил үйлчилгээ байна.


Зураг 29 . Ур чадварын зөрүү хамгийн их тулгардаг зургаан ажил үйлчилгээ



Хамгийн их эрэлт хэрэгцээтэй ур чадвар

Ажлын байрны шаардлагад нийцсэн ур чадвартай ажиллах хүч нь Монголын эдийн засгийн өсөлтийн гол түлхүүр юм. Монголын ажил олгогчдын хамгийн их үнэлдэг зургаан ур чадварыг Зураг 2-т харуулав.⁴

Зураг 30. Хамгийн эрэлттэй зургаан ур чадвар



Ажил олгогчдын чухалчилж байгаа бусад ур чадварт мэдээллийн технологийн (МТ) үндсэн/суурь ур чадвар, өөрийгөө удирдах чадвар буюу бие даан ажиллах чадвар багтаж байна.

Ажил олгогчдын хайж буй ур чадварууд гурван ангилалд хуваагдаж байна: (а) нийгэм- бүтээлч зан үйлийн ур чадвар (ажлын ёс зүй, харилцаа, багаар ажиллах, санаачилгатай байх); (б) танин мэдэхүйн чадвар (шинэ зүйлийг сурах хүсэл эрмэлзэл, чадвар); (в) тухайн ажлын байранд тохирох техникийн ур чадвар.

Ажил олгогчид мэргэжлийн ялгаатай бүлгүүдээс ялгаатай ур чадварын багцыг шаардах нь мэдээж юм. Гэсэн хэдий ч дээр дурдсан зургаан ур чадвар нь судалгааны хүрээнд авч үзсэн өргөн хүрээний ажил, мэргэжлийн дараах гурван бүлэгт нийтлэг хамаарах ур чадвар байна: (а) мэргэжилтэн, (б) биеийн хөдөлмөр шаарддаггүй ажил

4 Судалгаанд оролцогчдыг дараах гурван ангилалд хуваасан 25 ур чадварын жагсаалтаас хамгийн чухал гэж үзсэн ур чадвараа сонгохыг хүссэн: (а) танин мэдэхүйн ур чадвар (бичиг үсэг, тоо бодох, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх гэх мэт), (б) нийгэм - зан үйлдлийн ур чадвар, (в) тухайн ажлыг гүйцэтгэх техникийн ур чадвар.

гүйцэтгэгч (бичиг хэргийн, үйлчилгээ, борлуулалтын г.м), (в) биеийн хөдөлмөр болон ур чадвар шаарддаг ажил гүйцэтгэгч.

Хамгийн дутагдалтай байгаа ур чадвар

Монгол ажилтнууд ажил олгогчдод шаардлагатай байгаа ур чадваруудыг эзэмшиж чадсан байна уу? Ямар ур чадвар ажиллах хүчинд хамгийн дутмаг бөгөөд сайжруулах шаардлагатай байна вэ? Монголын ажил олгогчдын зүгээс ажиллах хүчинд дутагдалтай байна гэж үзэж байгаа зургаан гол ур чадварыг Зураг 3-т үзүүлэв.

Зураг 31. Хамгийн тэргүүнд сайжруулах шаардлагатай зургаан гол ур чадвар



Сайжруулах шаардлагатай бусад ур чадварт манлайлах буюу удирдах ур чадвар, гадаад хэлний чадвар, техникийн өндөр ур чадвар багтаж байна. Дахин онцлоход, ажиллах хүчинд дутагдалтай байна гэж ажил олгогчдын зүгээс үзсэн ур чадварын багц нь ажил, мэргэжлийн түгээмэл гурван бүлэг хооронд бага зэрэг ялгаатай байгаа боловч дээр дурдсан ур чадварыг нийтлэгээр бүгдийг нь сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Ажиллах хүчинд дутагдалтай байна гэж ажил олгогчийн зүгээс үзэж байгаа ур чадвар нь ажил олгогчдын хамгийн чухалчилж байгаа ур чадвартай үндсэндээ ижил байна. Ялангуяа, ажилтнуудад нийгэм-бүтээлч зан үйлийн ур чадвар, түүний дотор санаачилгатай байх, ажлын ёс зүй, шинэ зүйл сурах хүсэл эрмэлзэл, харилцаа, багаар ажиллах чадвар болон бие даан ажиллах чадвар (өөрийгөө удирдах) зэрэг ур чадвар дутагдаж байна. Үүнээс Монгол Улсад ур чадварын зөрүү

оршин байгаа нь мэдрэгдэж байгаа бөгөөд энэ нь техникийн болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар гэхээс илүүтэйгээр нийгэм-бүтээлч зан үйлийн ур чадварын зөрүүгээр илэрч байна.

Боловсролын тогтолцооны талаарх ажил олгогчдын үнэлгээ

Ажил олгогчид Монголын боловсролын тогтолцооны үр дүнд шүүмжлэлтэй хандаж байна. Ажил олгогчдын дийлэнх нь (80 орчим хувь нь) боловсролын систем нь тэдний бизнесийн үйл ажиллагаанд нийцсэн ур чадвартай хүмүүсийг бэлтгэж чадахгүй байна гэж үзэж байна. Тэд ялангуяа ТМБС-ын тогтолцооны үр дүнд шүүмжлэлтэй хандаж байгаа бол дээд боловсролын тогтолцооны үр дүнд арай эергээр хандаж байна.

Боловсролын систем нь, тухайлбал, техникийн ахисан түвшний шаардлагыг хангах, тухайн ажлын байранд тохирох ур чадвартай хүмүүсийг бэлтгэхгүй байгаад ажил олгогчид гомдолтой байна. Мөн түүнчлэн боловсролын байгууллагыг төгсөгчид орчин үеийн арга техник, технологийн талаарх мэдлэгээр дутмаг, ажлын байран дээрх хандлага нь сэтгэлд хүрдэггүй гэдгийг илэрхийлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын сургалт

Зарим аж ахуйн нэгж, байгууллагууд нь ур чадварын зөрүүг арилгах, ажилтнуудаа сургах талаар идэвхтэй ажиллаж байна. Ер нь дөрвөн аж ахуйн нэгж, байгууллага тутмын нэг нь ажилтнууддаа сургалт явуулж байна. Гэхдээ томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд, ТӨҮГ-д (том байх хандлагатай) болон инновацлаг компани, аж ахуйн нэгжүүд нь жижиг, хувийн болон уламжлалт аж ахуйн нэгж, байгууллагыг бодвол сургалт тогтмол явуулдаг байна. Энэ нь тэд илүү өндөр ур чадвартай ажилтан шаарддагтай холбоотой байж магадгүй бөгөөд үүний зэрэгцээ ажилтнуудаа сургах чадамжтай байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагууд нь мэргэжилтнүүдээ сургах магадлал өндөр, харин биеийн хөдөлмөр шаардсан ажил гүйцэтгэдэг ажилтнаа сургах нь бага байна.

Ерөнхийдөө, сургалтын зорилго нь ажилтнуудад үндсэн эсвэл техникийн өндөр ур чадвар, тухайн ажлын байранд шаардагдах ур чадвар олгоход, мөн хувь хүний хөгжлийг дэмжих (нийгэм- бүтээлч зан үйлийн ур чадварыг хөгжүүлэх)-д чиглэгддэг ажээ.

Дүгнэлт ба бодлогын зөвлөмж

Монгол Улсын ихэнх аж ахуйн нэгж, байгууллагын хувьд ажиллах хүчний ур чадвар тэдний үйл ажиллагаанд томоохон саад бэрхшээл учруулахаар асуудал болоогүй байна. Гэхдээ энэ нь Монгол Улсын ихэнх аж ахуйн нэгж, байгууллага нь жижиг хэмжээний, уламжлалт хэв шинжтэй байгаатай зарим талаар холбоотой юм. Харин том болон инновацлаг компани, аж ахуйн нэгжүүд илүү өндөр ур чадвартай ажилтан шаарддаг тул ур чадвартай ажиллах хүчний дутагдал тэдний үйл ажиллагаа, өсөлтөд саад тотгор учруулдаг гэж үзэх нь илүүтэй байна.

Түүнчлэн, ажилтны ур чадварын түвшин хангалтгүй байгаа нь өндөр ур чадвар шаардсан бизнесийн үйл ажиллагаа тухайлбал, судалгаа шинжилгээ, программ хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээний хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна. Асуудал нь зөвхөн техникийн болон тухайн ажлын байрны шаардлагад тохирсон ур чадварын дутагдлаар хязгаарлагдахгүй байна.

Ажил олгогчид, техникийн ур чадварын зэрэгцээ нийгэм-бүтээлч зан үйлийн ур чадварыг ижил түвшинд үнэлж байна. Мөн ажил олгогчид нийгэм-бүтээлч зан үйлийн зохих ур чадвар тухайлбал, ажлын ёс зүй, зан харилцаа, санал санаачилга, манлайлал, өөрийгөө удирдах зэрэг ур чадвар (тухайн ажлын байранд тохирсон ур чадвараас гадна) ажиллах хүчний дунд дутагдалтай байна гэж үзэж байна. Ажил олгогчид ажиллах хүчний ур чадвар дутмаг байгаад боловсролын систем, ялангуяа техникийн ба мэргэжлийн боловсрол, сургалтын (ТМБС) системийг буруутгаж байгаад гайхах зүйлгүй юм. Ажил олгогчдын зарим нь ажилтнуудынхаа ур чадварын зөрүүг арилгах, сургах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Эдгээр нь гол төлөв өндөр ур чадвартай ажилтнууд шаарддаг, тэднийг нэгэн зэрэг сургах чадамжтай том, инновацлаг компани, аж ахуйн нэгжүүд юм. Ийм сонголт нь жижиг аж ахуйн нэгж, байгууллагуудад тэр бүр байдаггүй.

Судалгааны эдгээр үр дүнгээс харахад цаашид баримтлах бодлогын чиглэлүүд маш тодорхой байна. Монгол Улсын аж ахуй нэгж, байгууллагуудын шинэчлэл болон өсөлт, улмаар нийт эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд ур чадварын зөрүүг арилгаж, ажиллах хүчний ур чадварыг сайжруулах шаардлагатай. Энэ зорилгод

хүрэхийн тулд дараах дөрвөн нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Техникийн ур чадвар болон нийгэм - бүтээлч зан үйлийн ур чадварын аль алиных нь эрэлт хэрэгцээний талаарх мэдээллийг бүх оролцогч талуудад идэвхтэй түгээж, Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системд байршуулан олон нийтэд хүртээмжтэй хүргэх шаардлагатай.
- Боловсрол, сургалтын байгууллагууд хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ур чадварууд, түүний дотор нийгэм-бүтээлч зан үйлийн үндсэн ур чадварыг хөгжүүлэхэд илүү сайн анхаарах хэрэгтэй. Зөөлөн ур чадварууд нь хүүхэд насандаа боловсрол эзэмших хамгийн эхэн үеэс буюу цэцэрлэг, бага сургуулиас эхлэн дунд боловсролоор дамжин хөгждөг.
- Ажил олгогчдын шаарддаг ур чадваруудыг оюутан, залуу ажилчин, ажил хайгчдад ойлгуулж таниулах хэрэгтэй бөгөөд ингэснээр тэдэнд ур чадварынхаа хөгжилд хөрөнгө оруулалт хийж, хөдөлмөр эрхлэх боломжоо нэмэгдүүлэхэд тусална. Түүнчлэн, оюутнуудыг ажлын байран дээр дадлагажуулах нь ажлын туршлага хуримтлуулах, тухайн ажлын байранд шаардагдах ур чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтнаа сургах замаар ур чадварын зөрүүг арилгахад идэвхтэй ажиллах, тухайн байгууллагад хэрэгцээтэй, тодорхой ажлын байранд шаардагдах ур чадварыг хөгжүүлэхэд залуу ажилтнуудыг дагалдуулан сургах нь чухал. Сургалт явуулах чадамжгүй жижиг аж ахуйн нэгж, байгууллагуудыг Засгийн газраас (жишээлбэл, татварын хөнгөлөлтөөр дамжуулан) дэмжих нь зүйтэй..

Ур чадварын зөрүүг багасгахад шаардагдах нөхцөлүүдийг Зураг 4-т хураангуйлан үзүүлэв.

Зураг 32. Ур чадварын зөрүүг багасгахад шаардлагатай нөхцөлүүд

Байнгын ажиллагаатай Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоо

- Хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа "зөөлөн" болон "хатуу" ур чадварын талаарх мэдээллийг сонирхогч бүх талуудад хүргэдэг.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд мэдрэмжтэй боловсрол, сургалтын байгууллагууд

- Хөдөлмөрийн зах зээл дээр шаардагдаж байгаа ур чадварыг хөгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлдэг.

Мэдээлэл сайтай оюутан, залуу ажилчин, ажил хайгчид

- Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварын талаар мэдээлэл олж аван, хөдөлмөр эрхлэх бсоломжоо нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай ур чадвараа хөгжүүлэхэд хөрөнгө оруулдаг.

Идэвх санаачилгатай аж ахуйн нэгж, байгууллагууд

- Хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа "зөөлөн" болон "хатуу" ур чадварын талаарх мэдээллийг сонирхогч бүх талуудад хүргэдэг.

Судалгааны дэлгэрэнгүйг та бүхэн ХНХСҮСИ-ийн цахим хуудас institute.gov.mn хаягаар уншна уу

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс,

хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 1995 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 2022-2023 оны хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, 2022 он
4. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
5. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2022 оны III улирал
Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2023 оны I улирал
10. “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа – Ур чадварын модулиар өргөтгөсөн” тайлан, 2023 он

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

www.legalinfo.mn
www.nso.mn
www.1212.mn
www.mlsp.gov.mn/sp-dictionary
www.ndaatgal.mn/v1/
www.hudulmur-halamj.gov.mn

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,
судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.institute.gov.mn

